

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт



БАТЛАВ:.....
МОНГОЛЫН ШҮҮХ ЭМНЭЛГИЙН
ШИНЖЭЭЧ ЭМЧ НАРЫН
НИЙГЭМЛЭГИЙН ДАРГА
Г.ДАГИЙМАА

ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖЭЭЧ ЭМЧ

“АХЛАХ” зэрэг горилогч шүүх эмнэлгийн шинжээч эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

Үүнд:

1. Тухайн мэргэжлээрээ тасралтгүй 8 жил ажилласан байх
2. Гадаад, дотоодын сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд жил бүр хамрагдсан байх (сертификатаар баталгаажуулна).
3. Эрдэм шинжилгээ судалгааны 5-аас доошгүй бүтээлийг тус бүр мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна. Үүнд: ховор тохиолдол 1-2 (өөрөө болон бусад эмч нартай хамтран оношилсон байх), судалгааны илтгэл 4-с доошгүй, үүнээс 1-р судлаачаар ажилласан илтгэл 2-с доошгүй байх.
4. Шинжээч эмчийн мэргэжлийн ур чадвар эзэмшсэн байх.

“ТЭРГҮҮЛЭХ” зэрэг горилогч шүүх эмнэлгийн шинжээч эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна .

Үүнд:

1. Гадаад, дотоодын сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд жил бүр хамрагдсан байх (сертификатаар баталгаажуулна).
2. Эрдэм шинжилгээ судалгааны бүтээлийг сүүлийн 5 жилд 5-аас доошгүй хэвлэн нийтлүүлсэн байна. Үүнд: өөрөө болон бусад эмч нартай хамтран оношилсон ховор тохиолдол 2-оос доошгүй, илтгэл 4, үүнээс 1-р судлаачаар ажилласан илтгэл, өгүүлэл-3 тус бүр мэргэжлийн сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн байна. Бүтээлд нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх, шинэ бүтээлийн эрх орж болно.
3. Шүүх анагаах ухааны шинэ технологи, инновацид суралцсан байх. Шүүх гэмтэл судлал, генетик, шүүх хор судлал, шүүх эд судлал, ИГХ-ийн будаг/биомаркерийн үр дүнг үнэлэх чадвар эзэмшсэн бол давуу тал болно.

4. Ахлах зэрэг хамгаалснаас хойш мэргэжлээрээ тасралтгүй 5 жил ажилласан, сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайлантай байх.
5. Залуу шинжээч эмч нар, ахлах зэрэгтэй шинжээч эмч нарт зөвлөгөө өгөх, мэргэжил, арга зүйгээр хангах чадвар эзэмшсэн, төгсөлтийн дараах сургалтын шүүх анагаахын сургагч багшаар ажиллаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэж, дагалдан болон шавилан сургасан байх.
6. Магистрын зэрэг хамгаалсан бол давуу тал болно.

“ЗӨВЛӨХ” зэрэг горилогч шүүх эмнэлгийн шинжээч эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

Үүнд:

1. Мэргэжлээрээ тасралтгүй 25-аас дээш жил ажилласан байх.
2. Гадаад, дотоодын сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд жил бүр хамрагдсан байна.
3. Шүүх анагаахын үндсэн мэргэшлийн сургагч багшаар ажиллаж, магистр, клиникийн профессор цолтой байх.
4. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлыг удирдах болон төслийн багт хамтран ажилласан, сүүлийн 5 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 6-аас цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх (үүнээс гадаадад 1-с цөөнгүй өгүүлэл хэвлүүлсэн байх ба бүтээлд нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх орж болно).
5. Шүүх анагаах ухааны оношлогооны шинэ арга, технологиос практикт нэвтрүүлэх, мэргэжлийн чиглэлээр оношлогооны бичиг баримт боловсруулсан байх, Үүнд: хууль, дүрэм, заавар, удирдамж, стандарт зэргийг боловсруулах багийг удирдсан, эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан байх.
6. Мэргэжлээрээ тасралтгүй ажилласан сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайлан бичгээр өгөх.
7. Докторын зэрэг хамгаалсан бол давуу тал болно.

ШҮҮХ ЭМГЭГ СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН ТЕХНИКЧ

“АХЛАХ” зэрэг горилогч лабораторийн техникч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

Үүнд:

1. Мэргэжлээрээ тасралтгүй 8-аас дээш жил ажилласан байх.
2. Тусгай будгийн 2-с цөөнгүй аргыг бие дааж гардан хийх чадвар эзэмшсэн байх.
3. Лабораторын орчин үеийн аппаратуудыг ажиллуулах, ашиглах мэдлэг чадвар бүрэн эзэмшсэн байх.
4. Судалгааны 2-с цөөнгүй тооны бүтээл хийж хэвлүүлсэн байх.

5. Мэргэжлээрээ тасралтгүй ажилласан сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайлан бичгээр өгөх.

“ТЭРГҮҮЛЭХ” зэрэг горилогч лабораторийн техникч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

Үүнд:

1. Ахлах зэрэг хамгаалснаас хойш тасралтгүй 8-аас дээш жил ажилласан байх.
 2. Тусгай будгийн 4-с цөөнгүй аргыг бие дааж гардан хийх чадвар эзэмшсэн байх.
 3. Лабораторын орчин үеийн аппарат техник ажиллуулах, ашиглах мэдлэг чадвар бүрэн эзэмшсэн байх.
 4. Шинээр суралцаж байгаа лаборантыг ажлын байранд дагалдуулан сургасан туршлагатай байх.
 5. Судалгааны 2-с цөөнгүй тооны бүтээл хийж хэвлүүлсэн байх.
 6. Мэргэжлээрээ тасралтгүй ажилласан сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайлан бичгээр өгөх.
-